МОНГОЛ
ШУУДАН



# “МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

# 2023


ӨДӨР БҮР
УУЛЗАХ
ҮНДЭСНИЙ
ШИЛДЭГ
КОМПАНИ
Фото зургийг **Г.Батсүх**
*Завхан аймаг, Эрдэнэхайрхан сум*
*Бор хярын элс*

# АГУУЛГА

## КОМПАНИЙН ЕРӨНХИЙ ТОЙМ


**4** Мэндчилгээ

**5** Төлөөлөн удирдах зөвлөл

**6** Компанийн 2023 оны зорилго, зорилтууд

**8** Монгол Шуудангийн түүх

**10** 2023 оны онцлох амжилтууд


## ХҮНИЙ НӨӨЦ, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА


**20** Тохижилтын ажил

**21** Хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны талаар

**22** Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төв

**23** Цахим шилжилт ажлын хүрээнд

**24** Шуудангийн технологийн ажлын хүрээнд


## ШУУДАНГИЙН ҮНДСЭН ҮЙЛЧИЛГЭЭ


**25** Улс хоорондын шуудангийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэх

**28** Хот доторх хүргэлт буюу гараас-гарт хүргэлтийн үйлчилгээ

**29** Улс хоорондын транзит шуудангийн үйлчилгээ

**29** Хот хоорондын тээвэр, логистикийн үйлчилгээ


## МАРК ҮНЭТ ЦААСНЫ ҮЙЛДВЭРЛЭЛ


**32** Марк, дугтуй, үнэт цаасны үйлдвэрлэл


## САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ


**42** Санхүү эдийн засгийн үзүүлэлт

**50** Аудитын тайлан

# Мэндчилгээ



Хүнну гүрнээс эхлэлтэй Өртөө шуудангийн буурал түүхтэй “Монгол шуудан” ХК-ийн баялаг түүхийг бүтээхэд өөрийн мэдлэг чадвар, хүч хөдөлмөрөө зориулсан үе үеийн ахмад буурлууд, Монгол орны өнцөг булан бүрд ажиллаж, амьдарч буй нийт шууданчид болон хамтран ажилладаг байгууллага, харилцагч, үйлчлүүлэгч, хувьцаа эзэмшигч та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Харилцаа холбооны салбар төдийгүй нийгмийн бүхий л салбарт цахим шилжилт хэмээн ойлголт хурдацтай хөгжиж байна. Цахим технологи, инновац зэрэг нийгмийн үсрэнгүй хөгжил дэвшлийн үр дүнд бидний өдөр тутмын амьдралын хэв маяг болон бизнесийг удирдах уламжлалт арга барил эрс өөрчлөгдөж бизнесийн шинэ загварт хурдацтай шилжиж байгааг бид бүхэн харж байна. Энэ ч утгаараа шуудангийн салбарын бизнес загвар, хүргэлтийн арга барил, техник технологи зэргийг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, шинэ техник, технологиудыг нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна. Монгол шуудан ХК-ийн хувьд 2023 онд шинэ техник технологиудыг нэвтрүүлэх, шуудангийн дэд бүтцийг өргөжүүлэх, шинэ бизнес загваруудыг нэвтрүүлэхэд чиглэсэн томоохон төслүүдийг хийж, хэрэгжүүлж, эхлүүлсэн жил байлаа. Бид 2023 онд “Хөшигийн Хөндий”-н нисэх онгоцны буудалд эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхнээс татан төвлөрүүлсэн хөрөнгөөр олон улсын шуудан ялган боловсруулах шинэ төвийг барьж ашиглалтад оруулахад бэлэн болгосон, “Буянт-Ухаа”-ийн карго терминалд Улс хоорондын газар шуудан ялган боловсруулах төвийн үйл ажиллагааг нээн ажиллуулж байна. Ингэснээр улс хоорондын шуудангийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шуудангийн үндсэн дэд бүтцээр дамжуулан монгол улсад цахим худалдааны бизнесийг хөгжүүлэхэд компанийн зүгээс хувь нэмрээ оруулна гэж зорин ажиллаж байна.

Эрхэм та манай компанийн 2023 оны жилийн тайланг хүлээн авна уу.

Гүйцэтгэх захирал Бадамрайн **АНХБААТАР**

# Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд



Даваахүү
НАРАНГЭРЭЛ
ТУЗ-ийн дарга



Банзрагч
ГАНБААТАР
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Одончимэд
ОДБАЯР
ТУЗ-ийн ердийн гишүүн
Стратеги, эрсдэлийн удирдлагын хорооны дарга



Даваасамба
ДЭЛГЭРМАА
ТУЗ-ийн ердийн гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга



Гэрэлт ТЭЛМЭН
ТУЗ-ийн гишүүн



Чүлтэм
АМАРБААТАР
ТУЗ-ийн хараат бус гишүүн



Дарамбазар
БАЛДОРЖ
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга



Батаа
БАТЦЭЦЭГ
ТУЗ-ийн гишүүн



Даваадорж
БАЛЖИННЯМ
ТУЗ-ийн гишүүн

МОНГОЛ ШУУДАН

# Монгол Шуудан ХК-ийн 2023 оны зорилго, зорилтын хэрэгжилт

**Компанийн эрхэм зорилго**

“МЭРГЭЖЛИЙН ХҮРТЭЭМЖТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛЖ НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛД ХУВЬ НЭМЭР ОРУУЛАХ”

**Компанийн алсын хараа**

“ӨДӨР БҮР УУЛЗАХ ҮНДЭСНИЙ ШИЛДЭГ КОМПАНИ”

**2023 оны зорилго, зорилтууд:**

Компанийн хувьд 2023 онд хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, гол нэр төрлийн бүтээгдэхүүний бодит өсөлтийг хангах, цахим шилжилтийг эрчимжүүлэн процессыг хөнгөвчилж, бүтээмжийг нэмэгдүүлэх, бүтээмжид суурилсан цалин урамшууллын системийг нэвтрүүлэн үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн, зорилго, зорилтуудыг дэвшүүлэн ажиллаа.

**Үйл ажиллагааны үндсэн чиглэл**

- Шуудангийн үндсэн ба уламжлалт нэр төрлийн үйлчилгээг хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх
- Тээвэр, логистикийн үйлчилгээг өргөжүүлэх
- Санхүүгийн цогц үйлчилгээг эхлүүлэх

| | Зорилго | Зорилтууд |
|---|---|---|
| 1 | **Шуудангийн үндсэн ба уламжлалт нэр төрлийн үйлчилгээг хөгжүүлэх, бодит өсөлтийг хангах** | ИМПОРТЫН ШУУДАНГ ХӨГЖҮҮЛЭХ |
| | | ЭКСПОРТЫН ШУУДАНГИЙН БОДИТ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ |
| | | И-ХУДАЛДААНЫ ХҮРГЭЛТИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ |
| | | ДОТООД ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ |
| | | БҮТЭЭМЖИД СУУРИЛСАН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН СИСТЕМИЙГ НЭВТРҮҮЛЭХ |
| 2 | **Тээвэр, логистикийн үйлчилгээг өргөжүүлэх** | ТРАНЗИТ ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ |
| | | ХОТ ХООРОНДЫН ЛОГИСТИК ҮЙЛЧИЛГЭЭГ ӨРГӨЖҮҮЛЭХ |
| 3 | **Санхүүгийн үйлчилгээг эхлүүлэх** | ГАДААД ВАЛЮТААРХ ОРЛОГЫН ӨСӨЛТИЙГ ХАНГАХ |

**1921-07-19**

Ардын Засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулав.

**1935**

Нийслэлийн Шуудангийн хороо

**1935-1936**

Нийслэлийн Төв Холбооны Төв шуудан тасаг

**1936-1958**

Холбооны Ерөнхий Хорооны харьяа

**1958-1960**

Төв Шуудан

**1966-1978**

Цахилгаан Шуудангийн хороо




Шуудан харилцаа нь Хүнну гүрний үеэс, он цагийг илүү наашлуулбал их эзэн Чингис хааны хүү Өгэдэй хааны дөрвөн сайн үйлийн нэг болох сайтар зохион байгуулсан өртөөт зам "**Монголын Морин Өртөө**"-нөөс үүсэлтэй.

Монголын морин өртөө шуудан нь үүсэл хөгжлөөрөө дэлхийн шуудан холбооны түүхэнд анхдагч тэргүүн зэргийн харилцаа холбооны нэгэн төрөлд тооцогддог билээ.

Монгол улс дэлхийн асар өргөн уудам нутгийг эзлэн оршиж байсан үед 1228-1241 онд Монголын эзэнт гүрний хаан ширээнд сууж байсан Чингис хааны гуравдугаар хөвгүүн Өгэдэй мэдээлэгч, захирагч нарыг бий болгож морин өртөө байгуулсан нь шуудан харилцааны хувьд уургын улаан халж, мэдээлэл харилцаа дамжуулах сүлжээг үүсгэн байгуулсан томоохон дэвшил билээ.

Өртөө нь улам боловсронгуй болон хөгжсөөр Ардын хувьсгал мандсан 1921 оны 7 дугаар сарын 19-нд Ардын засгийн газрын тэргүүлэгчдийн 6-р хурлын тогтоолоор Монгол улсын шуудан бичиг, цахилгаан мэдээний ерөнхий хороог байгуулсан нь одоогийн 100 жилийн түүхт Монгол Шуудан юм.

| 1978-1990 | 1990-1994 | 1994 | 2002 | 2009 | 2016 |
|---|---|---|---|---|---|
| Төв Шуудан | Цахилгаан Шуудан Холбооны газар Шуудан Холбооны газар | Монгол Шуудан ТӨҮҮГ | Монгол Шуудан ХХК | Монгол Шуудан ТӨХК | Монгол Шуудан ХК |






Шуудан хуваарилах тасаг
1950 он




Шууданч бүсгүй
1980 он



Шууданч бүсгүй
2023 он

Хувьцаат компанид шилжсэн шийдвэр:

**1. Монгол Улсын Их Хурлын 2015 он**

“Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай” 70 дугаар тогтоол

**2. Монгол Улсын Засгийн газрын 2015 он**

“2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалт батлах тухай” 330 дугаар тогтоол

**3. Төрийн өмчийн хорооны 2015 он**

“Нэмэлт хувьцаа гаргах тухай” 594 дүгээр тогтоолуудаар “Монгол Шуудан” ХК болгон өөрчлөв.

# 2023 оны онцлох ажлууд

## Дотоод шуудангийн чиглэлээр



### Дотоод шуудан хүргэлт

Дотоодын шуудан хүргэлтийн хэмжээ 2022 оноос 5 хувь өсч **2.3 сая** ширхэгт хүрлээ. Үүнд:

- E-Mongolia
- Банкны карт хүргэлтийн үйлчилгээний өсөлт голлон нөлөөллөө.



### Захиалгат хүргэлт, тээврийн үйлчилгээ

Шинэ жилийн бэлэг, Наадмын тасалбар, ЭЕШ-ын материал зэрэг улсын чанартай ОРОН ДАЯАР хүргэх үйлчилгээ болон цахим худалдааны илгээмж хүргэлтийн үйлчилгээг цаг тухай бүрт зохион байгуулж ажиллалаа.




### “ХУРДАН” төрийн үйлчилгээний оператор

Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хот болон аймгийн төвийн нийт 44 цэгт “ХУРДАН” үйлчилгээний цэгийн үйл ажиллагаа эхлүүлж, нийт **10061** орчим төрийн үйлчилгээг шуудангийн салбаруудаараа үзүүллээ.



## Улс хоорондын шуудангийн чиглэлээр



### ОХУ болон БНХАУ-тай хамтын ажиллагааны шат ахив

ОХУ болон БНХАУ-ын шуудантай хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлын хүрээнд:

- ОХУ-тай газар шууданг тогтмол солилцож эхэллээ
- Өвөр Монголын шуудантай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, газар шуудан солилцох, карго үйлчилгээ нэвтрүүлэхээр тохиролцов.




### Транзит шуудангийн харилцагчийн гэрээг шинэчлэв

ОХУ-ын хоригоос шалтгаалан транзит шуудангийн үйлчилгээний харилцагч солигдож, харилцагч солих, систем тохиргоо хийх, тээврийн үйл ажиллагааны шилжилтийг зохион байгууллаа.



### Гадаад шуудан ЯБТ-ийн барилгыг ашиглалтад хүлээн авахад бэлэн боллоо

Санхүүжилтийн асуудлаас болж зогсоод байсан гадаад шуудангийн ЯБТ-ийн барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэснээр барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад хүлээн авахад бэлэн боллоо.

## Дэд бүтэц, парк шинэчлэл



### Хот хүргэлтийн автомашин

Гараас гарт хүргэлт, ОН-ын хүргэлтийн чанарыг сайжруулахаар 16 автомашинаар парк хийж, ОН-ийн бүх аймгуудыг хүргэлтийн автомашинтай болгож, Улаанбаатар хотын хүргэлтийн автомашины тоогоо нэмэгдүүллээ.



### Орон нутгийн ачаа тээвэр

Хот хоорондын болон орон нутгийн шуудан тээврийн үйл ажиллагааны хэвийн, найдвартай байдлыг хангахаар 2-3 тоонын даацтай дунд оврын 6 ачааны автомашинаар парк шинэчлэл хийлээ.



### НҮБ, ДШХ төслөөр 3 автомашин авлаа

НҮБ болон ДШХ-ны хамтарсан техникийн чадавхыг сайжруулах төсөл болон ДШХ-ны чанарын сангийн төслийн 440 сая төгрөгийн санхүүжилтээр шинэ 2 ачааны автомашин, 1 ажилчдын автобус худалдан авлаа.

# 2023 оны онцлох ажлууд

## Хүний нөөцийн бодлогын хүрээнд



**1.**

Компанийн цахим шилжилт, бүтээмж нэмэгдүүлэх, зардал нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2023 оны 1-р сараас эхлэн хүний нөөцийн “GREEN ERP” программ, гар утасны аппликейшныг шинээр нэвтрүүлэх ажлыг хариуцан зохион байгууллаа. Энэхүү систем нэвтэрснээр:

Цагийн бүртгэл,

- Чөлөө авах, зөвшөөрөх, бүртгэл хөтлөх,
- Гадуур ажлын бүртгэл,
- Ээлжийн амралт эдлэх хүсэлт, бүртгэл
- Тушаал, шийдвэрийн бүртгэл
- Хөдөлмөрийн гэрээ зэрэг хүний нөөцийн хөдөлмөрийн харилцааг цахимжуулж, цаасгүй, цахим шилжилтэд хувь нэмэр оруулж байна.



**2.**

Хүний нөөцийн бүрдүүлэлтийн ажлын хүрээнд Монгол улсын их сургууль, Мандах их сургууль, Шинжлэх ухааны технологийн их сургуулиудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, төгсөх курсийн оюутнуудыг ажлын байраар хангаж ажиллаа.



**3.**

Түгээмэл мэргэжлийн ажилтнуудыг СОНГОН ШАЛГАРУУЛЖ АЖИЛД АВАХ, СУРГАЖ ДАДЛАГАЖУУЛАХ ЖУРАМ шинээр боловсруулан батлуулж, 2023 оны 11-р сараас эхлэн Улаанбаатар хотын 22 салбар нэгжүүдэд хэрэгжүүлэн ажиллаж байна.





**7.**

Харилцаа холбоо мэдээллийн технологийн салбарын 7 төрөлт спортын их наадамд компаниа төлөөлөн Улаанбаатар хотоос 30 тамирчин, орон нутгаас 5, нийт 35 тамирчин амжилттай оролцож:

- Эмэгтэй шатар ганцаарчилсан төрөлд Мөнгөн медаль
- Эмэгтэй 3x3 сагсан бөмбөгийн төрөл Мөнгөн медаль
- Эрэгтэй 5x5 сагсан бөмбөгийн төрөлд Хүрэл медаль
- Эмэгтэй 5x5 сагсан бөмбөгийн төрөлд Хүрэл медаль тус тус эзлэн хамт олондоо урам өглөө.



**4.**

Компанийн сургалт, хөгжлийн бодлогын хүрээнд “СУРГАЛТ СУДАЛГААНЫ ПОЛИСИ” төвтэй хамтран ажиллах гэрээ байгуулан, батлагдсан хуваарийн дагуу ажилтнуудад сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.



**5.**

Ажилтнуудыг ажлын байрны нөхцөлийг сайжруулах, нийгмийг асуудлыг нь шийдэх зорилгын хүрээнд Төв оффист ойр Чингэлтэй дүүргийн 5 дугаар цэцэрлэгтэй хамтран ажиллаж, Улаанбаатар хотын 9 ажилтны хүүхдийг цэцэрлэгт хамрууллаа.



**6.**

Түүнчлэн компанийн төв оффист хүүхдийн өрөөг шинээр тохижуулснаар түр хугацаагаар хүүхдээ ажлын байран дээр байлгах, сэтгэл тайван ажилдаа анхаарах орныг бүрдүүлэн өглөө.



**8.**

“Ахмадын баяр”-ийг тохиолдуулан Улаанбаатар хотод буй компанийн 244 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.



**9.**

2023 онд хамт олны дундаас ажил үйлсээрээ бусдыгаа хошуучлан, үр дүнтэй ажилласан нийт 131 ажилтнуудыг Төрийн одон медаль, Яамны болон компанийн шагнал урамшууллаар шагнан урамшууллаа.

# 2023 оны онцлох ажлууд

## Газар шуудан солилцооны чиглэлээр

**Газар шуудан солилцооны чиглэлээр*

Хөрш орнуудтай газар шуудан солилцох чиглэлээр хамтран ажилласнаар ОХУ болон БНХАУ-тай газар шуудан солилцоог эхлүүлэн жигдрүүлээд байна. Цаашид бүс нутгийн орнуудтай шуудан солилцох транзит бүс болох зорилгоор ажиллаж байна.

**Улс хоорондын шуудангийн бизнес өргөжүүлэлт, дэд бүтцийн чиглэлээр*

Хөшигийн хөндийд байрлах дахь шинэ нисэх буудлын Улс хоорондын агаарын шуудан ялган боловсруулах төвийн барилгын ажил дуусаж ашиглалтад хүлээн авахад бэлэн болоод байна.




**Улс хоорондын шуудангийн бизнес өргөжүүлэлт, дэд бүтцийн чиглэлээр*

Буянт-Ухаа терминалд Улс хоорондын газар шуудангийн ялган боловсруулах төвийг 2023 оны 06-р сарын 02-ны өдрөөс албан ёсоор нээж, шуудан- карго тээврийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын агаарын болон газрын экспорт, импортын ачааг гаалийн хяналтын бүс хооронд шилжүүлэн тээвэрлэх, гаалийн хяналтын бүсэд ачаа хүлээн авах, гаалийн үзлэг шалгалтад хамруулах, бүртгэн хадгалах, хүлээн авагчид олгох, гаалийн бүрдүүлэлт хийх зэрэг үйл ажиллагааг эхлүүлсэн.

**Олон улсын төсөл, арга хэмжээ*

ДШХ-ны чанарын сангийн 160 сая төгрөгийн санхүүжилтээр 3.5 тонны даацтай ачааны автомашин, ДШХ болон НҮБ-ын хамтарсан 280 сая төгрөгийн санхүүжилтээр 16 хүний суудалтай Тоёота HiAce автобус худалдан авах төсөлд шалгарч нийт 440 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татлаа.





## 2023 оны онцлох ажлууд

### Дотоод шуудан тээвэр, хүргэлтийн чиглэлээр

1.

Монгол шуудан компани 2023 онд улс орны өнцөг булан бүрд ажиллаж амьдарч буй нийт шууданчдаараа дамжуулан нийт 2.3 сая шуудан илгээмжийг хүлээн авч, хаягт эзэнд нь гардуулан ажиллаа. Шуудан илгээмжийн хэмжээ жил бүр өсч байгаа бөгөөд 2023 онд өнгөрсөн оноос 5 орчим хувиар солилцооны тоо өслөө.




2.

2023 онд компанийн автобааз болон Логистикийн үйлчилгээний хамт олон орон нутгийн логистик тээврийн үйлчилгээгээр 1.1 сая км замыг аюул осолгүй, амжилттай туулан хэрэглэгч, үйлчлүүлэгчдэдээ хүрч ажиллаа.

3.

Хот хоорондын шуудан тээврийн үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлж, өөрийн тээврийг хөгжүүлж эхэлснээр зам дагуух болон хотын ойролцоох 70 сумын шуудангийн Улаанбаатар хотоос шууд бэлтгэн хүргэж, сумдын шуудангийн чанар хурдыг нэмэгдүүлж ажиллаа.



4.

Түүнчлэн Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг хорооны шуудангийн автомашинтай хүргэлтийн үйлчилгээг эхлүүлснээр хүргэлтийн хурд, чанарыг нэмэгдүүлэхээс гадна хүргэлт хийхэд хүндрэлтэй дүүрэг хороодод ажилладаг шууданчийн ажлын бүтээмжийг 2 дахин нэмэгдүүлэв.

**Хамтын ажиллагааны хүрээнд*



5.

Жил бүрийн Элсэлтийн ерөнхий шалгалтын материалыг энэ жил ч мөн аюулгүй, найдвартай хүргэлт, тээвэрлэлт хийж, уламжлал болгон зохион байгуулав















6.

Шинэ жил болон, Хүүхдийн баярыг тохиолдуулан бэлэг хүргэлтийн үйлчилгээгээр дамжуулан 6000 хүүхдэд бэлэг хүргэж баярлууллаа

7.

Цахим хөгжил харилцаа холбооны яам, Нийслэлийн засаг даргын тамгын газар, Баяр наадам зохион байгуулах комисстой хамтран Баяр наадмын билет хүргэлтийн үйлчилгээг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулав

8.

И-Монгол, бүх арилжааны банкуудтай хамтран 100 мянган жолооны үнэмлэх, 50 мянган иргэний үнэмлэх, 1 сая иргэний банкны карт хүргэж гардууллаа.

*Парк шинэчлэл*

9.

Гараас гарт хүргэлтийн үйлчилгээ болон холын хүргэлтийн үйлчилгээнд ашиглах нийт 22 авто машины худалдан авалтыг хийснээр хүргэлтийн хүчин чадлыг 40% нэмэгдүүлэв





10.

2023 онд багтаан 21 Аймгийн ШҮГ-үүдыг 100% хүргэлтийн автомашинаар хангалаа. Ингэснээр орон нутгийн шуудан илгээмжийг хүргэлтийн хурд, чанар сайжрах нөхцөлийг бүрдүүллээ.


MONGOL POST
ТӨВ ШУУДАН
ХУРДАН

## 2023 оны онцлох ажлууд

### Олон нийтийг хамарсан арга хэмжээ



1.

Олон улсын 52 дэх удаагийн захидлын уралдааныг зохион байгуулахад хамтран оролцож, үндсэн сүлжээ эзэмшигчийн хувьд 21 аймаг, 330 сумаас оролцуулахад дэмжин ажиллаа.



2.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хамгийн том арга хэмжээ болох “ICT EXPO 2023” 06 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд Үндэсний Соёл Амралтын Хүрээлэнд зохион байгуулагдлаа. “Монгол шуудан” ХК “Ард санхүүгийн нэгдэл” хамтран 7 дахь жилдээ амжилттай оролцож, үйл ажиллагаагаа сурталчиллаа.


3.

“Монгол Шуудан” ХК, “Дэвшилтэт Социал Демократ клуб ТББ”, “Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз”, “Боловсролын Ерөнхий Газар” -тай хамтран хүслийн захидал аяныг монгол орон даяар зохион байгуулж, улсын хэмжээний сургуулийн сурагчдын хүслийг сонсох аянд дэмжиж оролцлоо.

**Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх чиглэлээр*



4.

Төрийн “Хурдан” үйлчилгээг Монгол Шуудан компанийн Улаанбаатар хот дахь 22 салбар, Орон нутгийн аймгийн төвүүд дэх 22 салбараараа дамжуулан үзүүлж, нийт 44 цэгээр төрийн бүх шатны 440 гаруй үйлчилгээг операторын горимоор хүргэж, хамтран ажиллаа.

2023 онд нийт 800 гаруй мянган иргэнд төрийн “Хурдан” үйлчилгээ хүргэсэн байна.


5.

ЦХХХЯ, “Монгол Шуудан” ХК хамтран хаягжилтын сайжруулах, онцгой болон түргэн, хүргэлтийн үйлчилгээг сайжруулах зорилгоор Сүхбаатар дүүргийн 18-р хороонд 2,200 гаруй хашаанд “**what3words**” хаяг бүхий жишиг хаягжилтыг хийж, олон нийтэд хүргэлээ. Эдгээр хаягийн самбар нь оршин суугчдын дунд олоход хялбар, тодорхой 3 үгт хаягуудын талаарх ойлголтыг бий болгох, цахим худалдааны шуудан хүргэгч, яаралтай тусламжийн багууд маршрут, үйл ажиллагаагаа оновчтой болгоход туслах гэсэн хоёр талын үр ашигтай байх юм.

## 2023 оны онцлох ажлууд

### Тохижилтын чиглэлээр













Аж ахуй үйлчилгээний алба нь өөрсдийн дотоод хүн хүчээр Хэнтий аймгийн ШҮС-ыг засварлаж, хэрэглэгчдэд тав тухтай үйлчлэх орчныг бүрдүүлж өглөө.

Улаанбаатар хотод шинээр байгуулагдсан “Буянт-Ухаа” нисэх буудлын карго терминал, ШУ-ний 40, 44-р салбар, 21-р салбаруудыг бүрэн засварлаж, ая тухтай, тохилог орчныг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулан ажиллалаа. Түүнчлэн дээрх салбаруудын тавилгуудыг өөрсдөө шинээр хийж, компанийн зардлыг хэмнэж, ая тухтай ажиллах нөхцөлийг нь сайжрууллаа. Удахгүй дараа дараагийн салбаруудаа тохижуулахаар очих болно.



## Хүний нөөцийн мэдээлэл

2023 оны жилийн эцсийн байдлаар компанийн хэмжээнд **6** газар, **2** хэлтэс, **2** алба, **5** төв, **1** автобааз**, 6** дүүргийн шуудангийн үйлчилгээний газар, хэлтэс, Аймгийн шуудангийн үйлчилгээний газар гэсэн бүтцийн өөрчлөлтөөр шинэчлэгдсэн.

Ажиллах хүч нь Улаанбаатар хотын газар, хэлтэс, алба, төв, Шуудангийн үйлчилгээний газар, салбарт **468**, Хүүхэд асрах чөлөөтэй **64**, Аймгийн шуудангийн үйлчилгээний газарт **488**, нийт **1020** ажилтан бүртгэлтэй байна.

"Монгол Шуудан" ХК-ийн нийт ажиллах хүчний Улаанбаатар хотод- **45.8%,** Аймгийн шуудангийн үйлчилгээний газарт **54.2%** ажиллаж байна.




Улаанбаатар хот / Аймаг

Хүйсийн хувьд авч үзвэл, **70%** хувь нь эмэгтэй, **30%** хувь нь эрэгтэй ажилтан байна.




Эрэгтэй / Эмэгтэй

**Нийт ажилтны тоо**






Компанийн ажилтнуудын дундаж насыг сүүлийн 5 жилийн байдлаар харвал 2023 онд 35 нас байна.

## 2023 оны онцлох ажлууд

### Хэрэглэгчийн үйлчилгээний лавлах төв

Нийт 133.329 дуудлага ирснээс 101681 (81.1%) дуудлагыг амжилттай авч хариулсан бол 14926 (11.9%) дуудлага алдаж, хэрэглэгч өөрөө 12.967 (10.3%) дуудлагыг хүлээн авахаас өмнө тасалж, 3513 (2.8%) дуудлагыг өөр хэсэгт шилжүүлэн хариу өгсөн байна. Нэг дуудлагын дундаж хугацаа нь **1 мин 00 секундийн** хугацаатай байв.

- ХҮТ-1613-т 125,276 (93.9%) дуудлага ирсэн.
- Газар хэлтэст 606 (0.4%) дуудлага ирсэн.
- УБ-ын ШҮС-т 4,952 (4%) дуудлага ирсэн.
- Аймаг орон нутгийн ШҮГ-т 4,752 (3.5%) дуудлага ирсэн.



**Нийт хандсан дуудлага 135,386**

- ШҮГ, ШҮСалбарт хандсан дуудлага 9,704 (7.2%)
  - Амжилттай дуудлага 6,862
  - Алдсан дуудлага 1,396
  - Хэрэглэгч тасалсан 1,446
- Газар хэлтсүүдэд хандсан дуудлага 606 (0.4%)
  - Амжилттай дуудлага 113
  - Алдсан дуудлага 148
  - Хэрэглэгч тасалсан 345
- Лавлах **1800-1613** дугаарт хандсан дуудлага 125,034 (92.4%)

| | |
|---|---|
| Фэйсбүүк чат, коммент | 1,7697 |
| Утсаар | 100,293 |
| Имэйл /customercare@mongolpost.mn/ | 133 |
| Дуут шуудан /колл про/ | 100 |
| УХШ хяналт /лавлагаа илгээсэн, хариулсан/ | 873 |
| Эргэж холбогдсон дуудлага | 361 |
| ДШХ-ийн тест дуудлага | 84 |
| УХШ хяналт /лавлагаа илгээсэн, хариулсан/ | 882 |
| Эргэж холбогдсон дуудлага | 4,114 |



## Цахим шилжилт ажлын хүрээнд



ШУУДАН БҮРТГЭЛИЙН **ПОСТНЕТ** СИСТЕМ

Постнет V4 системийг 2022 оны 10-р сарын 21 өдрөөс эхлэн нэвтрүүлж эхэлсэн ба **IPS** болон **CDS** системтэй холболт амжилттай хийгдсэн. Системийн сайжруулалтын ажлын хүрээнд хийгдэж буй ажлуудын гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

**И-оффисын** систем нэвтрүүлэлтийн бэлтгэл ажил амжилттай хийгдэж байна.

Цалин, хүний нөөцийн системд шаардлагатай өгөгдөл дата оруулах, Veritech ERP системтэй холболт хийх ажлуудад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байна.

- 8 жилийн дараа системийн шинэчлэл хийгдсэн
- 20 сая шуудангийн өгөгдөл боловсруулах чадамжтай
- Хаягийн сан бүрдүүлж эхэлсэн
- Аппликейшн шинэчилсэн
- Тээвэр, маршрут үүсгэдэг болсон

**Цалин, Цаг бүртгэл, Хүний нөөцийн систем**

- Цалин урамшууллын шаталсан систем мөрдөх боломжтой
- Чөлөөний хүсэлт, үүрэг даалгаврын хяналт хялбар болсон
- Мэдээлэл хянах боломжтой
- Ажилчид мобайл аппликейшн ашиглана
- Царай таниулах төхөөрөмж, цаг бүртгэл
- Хүртээмжтэй байдал нэмэгдсэн

**CDS** (Customs Declaration System)

- Улс хоорондын гаалийн системд нэгдсэн
- Илгээмжийн мэдээллийг цахимаар урьдчилан солилцдог болсон



**International Postal System 2021 upgrade**

Улс хоорондын шуудангийн бүртгэлийн систем IPS-ийн 2017-оос 2021 хувилбарт шилжих ажлын урьдчилсан бэлтгэн ажлыг зохион байгуулж, шилжсэний дараах холбогдох тохиргоонуудыг хийн хэвийн ажиллах нөхцөл боломжоор хангаж ажилласан.

- IPS2017 > IPS2021 хувилбарт шилжсэн

**Транзит шуудангийн систем**

- Харилцагч тус бүртээ илгээмжийн төрлөөс хамаарсан бүрэн автомат мэдээлэл солилцох системийг хөгжүүлж, нэвтрүүлсэн



ХУРДАН
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦЭГ - ХААНААС Ч ОЙРХОН

## Шуудангийн технологийн ажлын хүрээнд

**Хурдан төрийн цахим үйлчилгээ** – Нийслэл Улаанбаатар болон 21 аймагт амжилттай нэвтрүүллээ.




Төрийн үйлчилгээний "Хурдан"-г Монгол шуудангийн Улаанбаатар хот дахь **22** салбар, Орон нутгийн аймгийн төвүүд дэх ШУГ **22** салбар нийтдээ **44** цэгт төрийн бүх шатны 440 гаруй үйлчилгээг, Орон нутгийн 73 төрлийн үйлчилгээг иргэдэд цахимаар операторын горимоор хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх ажлыг хийж гүйцэтгэхэд хамтран ажиллаа.



Хурдан цэгээр ирж үйлчлүүлэхдээ иргэний үнэмлэх эсвэл өөрийн нэр дээр бүртгэлтэй утасны дугаартай өөрийн биеэр МОНГОЛ ШУУДАН – ШУС болон ШУГ-т ирж үйлчилгээ авах боломжтой болоод байна.



Орон нутгийн салбаруудад "хурдан" үйлчилгээний нээлтийг "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар"-аас 4 сарын 28-5 сарын 26 хүртэл шат дараатайгаар нээлтийг үйл ажиллагааг зохион байгуулсан. Нээлт болох аймгуудад хуваарийн дагуу бүх шаардлагатай тоног төхөөрөмж болон гэрэлт хаяг дотор хаягийг байршуулж шаардлагатай мэдээллээр БТХГ, МТГ хамтран хийж гүйцэтгэлээ.



# УЛС ХООРОНДЫН ШУУДАН

## Улс хоорондын шуудангийн үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг олон улсын түвшинд хүргэх талаар

### УЛС ХООРОНДЫН ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, СОЛИЛЦООНЫ ТАЛААР



**Орох шуудан:**

УХАШЯБТ нь тайлант хугацаанд **100.4 тонн, 65,667 ширхэг** шуудан гаргасан бөгөөд өнгөрсөн мөн үеийнхээс жин нь 16.5%-иар буурсан бол, тоо ширхэг нь 16.1%-иар өссөн үзүүлэлтэй байна:

**Гарах шуудан:**

**144.6 тонн, 100,177 ширхэг** орох шуудан хүлээн авч ялган боловсруулсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс жингийн хувьд 16.7%-иар, тоо ширхэг нь 20.5%-иар тус тус буурсан үзүүлэлтэй байна.

## Чанарын тайлан мэдээлэл, чанар сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд

### УЛС ХООРОНДЫН ГАЗАР ШУУДАН, КАРГО АЧААНЫ СОЛИЛЦОО, ОРЛОГЫН ТАЛААР

УХГШЯБТ нь 2023 оны 06-р сарын 02-ны өдрөөс албан ёсоор нээлтээ хийн шуудан, карго тээврийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын агаарын болон газрын экспорт, импортын ачааг гаалийн хяналтын бүс хооронд шилжүүлэн тээвэрлэх , гаалийн хяналтын бүсэд ачааг хүлээн авах, гаалийн үзлэг шалгалтад хамруулах, бүртгэн хадгалах, хүлээн авагчид олгох, гаалийн бүрдүүлэлт хийх зэрэг үйл ажиллагааг явуулж эхлээд байна.

Чингэс хаан нисэх буудлаас агаарын **4,219** богц, **79.9** тонн ачаа, Амгалан, Сонсголон, Гурвалжин дахь гаалийн хяналтын бүсээс газрын **1,223** богц, **51.4** тонн ачаа нийт **5,442** богц, **131.4** тонн ачаа татаж гаалийн хяналтад оруулсан байна.

Гаалийн баталгаат агуулахад орсон 29 ачаанд гаалийн бүрдүүлэлт хийж, 516'400.0 төгрөгийн бүрдүүлэлтийн орлого, подоон түрээсээр **160** подоон ачааг хадгалж 800'000.0 төгрөгийн орлогыг тус тус олсон байна.

**5,442** богц бүхий **32,554** ширхэг ачааг гаалийн хяналт шалгалт, рентгенээр оруулж шалгуулснаас **31,352** ширхэг ачааг хүлээн авагчид шууд олгож, 1002 ширхэг ачаа нь гаалийн байгууллагад саатуулагдаж олгогдсон байна. Үүнээс **704** ширхэг ачаа нь хяналтын хугацаандаа буюу 3 хоногийн дотор олгогдож, хадгалалтын хугацаа хэтрүүлсэн **301** ширхэг ачаанаас 2'765'050.0 төгрөгийн орлогыг олсон байна.



## Тээвэр зууч, логистикийн ажлын хүрээнд

### Чанарын тайлан мэдээлэл, чанар сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хүрээнд

**Гарах шууданг** УХШЯБТ дээр илгээмжийн маягтууд(CP72, CN22/23)-ын үнэн зөв бөглөсөн эсэхэд өдөр бүр хяналт тавьж гаргаж буй зөрчлийг илрүүлэн, арилгах аяныг 2 удаа зохион байгуулсан.

Мөн салбар, нэгжүүдийн IPS бүртгэлийн систем дэх мэдээллийн **87** зөрчлийг илрүүлэн холбогдох тохиргоонуудыг хийж тухай бүрд заавар зөвлөгөөгөөр хангаж ажилласан.

**Орох шуудангийн** хүргэлт гардуулалтыг сайжруулах ажлын хүрээнд чанарын хяналтын систем(EMSSmart, QCSbd,)-үүдээр өдөр бүр хяналт тавин ШУГ, ШУС-уудаар илгээмжийн хүргэлтийг хийлгүүлэх, системийн мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв оруулах ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах, цаашид гаргуулахгүй байх заавар зөвлөмжийг нийт шуудан үйлчилгээний газар, салбарууд өгч ажиллалаа. Тайлант хугацаанд НШҮГазруудад **579** зөрчил, АШҮГ-уудад **188** зөрчил илэрсэн байна.





## Тээврийн маршрутыг оновчлох

УХШ-ийн орлого, солилцоог нэмэгдүүлэхийн тулд Ази, Европ болон бусад улсуудад шуудан гаргах маршрутыг тогтоон, **88** улс руу шуудан явуулах боломжтой болсон. Азийн орнуудыг Япон улсын шуудангийн байгууллагаар, Европ, Африк болон бусад улсууд руу Туркийн шуудангийн байгууллагаар нээлттэй дамжуулан 60-аад улсад, зөвхөн агаарын тээврийн байгууллагаар дамжуулан 24 улсад хаалттай богцоор хэлбэрээр шуудан илгээж байна.



## Төсөл хөтөлбөрийн хүрээнд

QSF-гийн санхүүжилтээр "Шинэ нисэх буудал болон ЯБТ-ийн хоорондох шуудан таталтыг сайжруулах" төслийн хүрээнд 2.5-3 тонны даацтай ачааны тээврийн хэрэгслийг худалдан авах төслийг боловсруулан хэрэгжүүлэх саналаа ДШХ-ны Үйлчилгээний чанарын санд хүргүүлээд байна.

## Хамтын ажиллагааны хүрээнд

МИАТ, Туркиш Эйрлайнс, АНА тээврийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээгээ шинэчилж хийн, Аэрофлотын тээврийн гэрээг Артис Ложистик компаниар дамжуулан мөн Солонгос улсын "CJ" логистик компанитай шуудан тээвэрлүүлэх гэрээг шинээр хийгээд байна.



## Тээвэр зууч, логистикийн ажлын хүрээнд

### Хот доторх хүргэлт - гараас гарт хүргэлтийн үйлчилгээ



- Уламжлалт явган хүргэлтээс, үе шаттайгаар автомашинтай хүргэлт рүү шилжих
- Автомашины тоог нэмэгдүүлж, Улаанбаатар хотын болон Орон нутгийн хүчин чадлаа нэмэгдүүлэв
- Бүртгэлийн систем, Вэбсайтын шинэчлэлээр онлайн захиалга, хүргэлтийг шинэ шатанд гаргана

### e Mongolia: Наадмын тасалбар захиалга, хүргэлт



- Төрийн цахим үйлчилгээ өргөжиж, шуудангаар авах үйлчилгээний нэр төрөл нэмэгдэж байна.
- e Mongolia - аар захиалсан 84,942 ширхэг иргэний үнэмлэх, жолооны үнэмлэхийг хүргэв
- Үндэсний их баяр наадмын тасалбар 5,989 ширхгийг шуудангаар хүргэв

### B2C захиалгат хүргэлт




- Орифлэйм, Хэрбалайф компанийн хотын доторх болон орон нутгийн тогтмол хүргэлт
- Оюутолгой, Хаанбанк, Голомт банк зэрэг томоохон харилцагчдын захиалгат хүргэлт
- Вэллбий, Hibox зэрэг онлайн худалдааны захиалгат хүргэлт
- Баяр ёслолын үеийн захиалгат хүргэлт



Нийт **118,446** ширхгийг хаягт эзэнд нь хурдан, шуурхай хүргэлээ.

## Улс хоорондох транзит шуудангийн үйлчилгээ




**Хэмжээ** |сая,ширхэг

2022 он — 17 сая ш

2023 он — 7 сая ш

**151** ТИР тээвэр

**13** Нислэг

## Хот хоорондын тээвэр, логистикийн үйлчилгээ



Хот хоорондын тээврээр Улаанбаатар хотоос бүх аймагт өөрийн тээврээр **170** рейсээр **156,772** ширхэг логистикийн ачаа тээвэрлэн хүргэж, 695 сая төгрөг төвлөрүүллээ.

## Санхүүгийн үйлчилгээ ажлын хүрээнд

МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ҮЙЛЧИЛГЭЭ “Монгол шуудан” ХК нь Ард Кредит ББСБ-тэй хамтран Улс хоорондын мөнгөн гуйвуулгын үйлчилгээ Еврожайро системд нэгдсэнээр 2023 онд нийт **2130** удаагийн давтамжтайгаар **4,461,149,406.82₮** -н гүйлгээг амжилттай хийгээд байна. Бид цаашдаа мөнгөн гуйвуулгын үйлчилгээг илүү өргөжүүлэх хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хот болон орон нутгийн шуудан үйлчилгээний салбаруудаар үзүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

| | 2022 он | 2023 он |
|---|---|---|
| Давтамж | 1987 | 2130 |
| Дүн | 4,893,886,125.57₮ | 4,461,149,406.82₮ |
| Улсууд | **29** | **31** |

## Тээвэр зууч, логистикийн ажлын хүрээнд

### ГАДААД ШУУДАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

**Гарах шуудан**

**Шуудан экспортын хэмжээ** |ширхэг:




**Шуудан экспортын хэмжээ** (жингээр):




**Орох солилцоо**




**144.6 тонн, 100177 ш**
жин: ▼ **16.7%**
тоо ширхэг: ▼ **20.5%**

# Дотоод шуудангийн үйл ажиллагаа

Энэ онд нийтдээ **146316** ширхэг богцоор, **1259** тн жинтэй, нийтдээ **2263829** ширхэг шуудангийн илгээмжийг хүлээн авч, ялган боловсруулж, хүргэсэн байна.

Орон нутагт шуудан хүргэх тээврийн хуваарийг сар бүр гарган батлуулж, хуваарийг мөрдүүлэн ажиллаж байна

Монгол Улсын хэмжээнд 7 хоногт 21 аймагт 6 удаа, 42 суманд 3 удаа, 132 суманд 2 удаа, 153 суманд 1 удаа, Улаанбаатар хотын Шуудангийн үйлчилгээний 40 гаруй салбарт өдөрт 2 удаа шуудан хүргэж байна.

- **Буухиа шуудан 56,321 ширхэг**
- **Бичиг захидал 2,005,903 ширхэг**
- **Боодол 134,509 ширхэг**
- **Илгээлт 62,048 ширхэг**
- **Хэвлэл 2,389,874 ширхэг**

хүлээн авч, ялган боловсруулж, хүргэсэн нь илгээмжийн солилцоо 2258781 ширхэгт хүрсэн байна. Хэвлэлийн солилцоо **2389874** ширхэгийг тус тус ялган боловсруулж, хүргэжээ.

Солилцоог өмнөх оны мөн үетэй харьцуулахад илгээмжийн солилцоо 6,8%-иар өссөн, хэвлэлийн **18%**-иар буурсан үзүүлэлттэй байна.

## Дотоод шуудангийн солилцоо



# 2023 оны онцлох ажлууд

## 2023 онд гаргасан маркууд



*Марк, үнэт цаасны хэлтсээс 2023 онд нийт 23 сэдвийн маркийг гүйлгээнд оруулан мөнхөлж, Монгол маркийн 100 жилийн ойг угтан маркийн үзэсгэлэнгүүдийг зохион байгуулсан, үйл ажиллагаагаа сурталчлан таниулсан жил боллоо.

2023 оны
1-р сарын 23







*Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханы Их Британи улс дахь айлчлалын хүрээнд “Монгол Улс, ИБУИНХУ хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жил” сэдэвт маркийн нээлтийг Лондон хотноо амжилттай зохион байгуулав. Энэхүү маркийг бүтээхэд Гадаад харилцааны яам, Монгол Улсаас ИБУИНХУ-д суугаа элчин сайдын яам, ИБУИНХУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Монгол шуудан компани болон Британийн “Рояаль Мэйл” шуудангийн алба хамтран ажилласан юм.

2023.06.06



*“Төмөр замын хөгжил” Маркийн үзэсгэлэн





*Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Гэгээн Ширээт Улсын Төрийн тэргүүн Пап Францисын манай улсад төрийн айлчлал хийсэнтэй холбогдуулан “ПАП ФРАНЦИСЫН МОНГОЛ УЛС ДАХЬ АЙЛЧЛАЛ”сэдэвт маркийг гүйлгээнд гаргаж хоёр улсын харилцаанд шинэ хуудас нээсэн түүхэн үйл явдалд хувь нэмэр орууллаа.



*2023 онд МҮЦХ-ийн хамт олон Хэнтий, Завхан, Архангай, Төв зэрэг 4 аймгийн түүхт 100 жилийн ой тохиож буйтай холбогдуулан 100 жилд зориулсан маркийг нь бүтээлээ. Аймгуудын ШУГ-ын үйл ажиллагаа, борлуулалтыг дэмжин орон нутагт нь маркийн нээлтийг зохион байгуулав.

2023.03.23



*“Үлэг гүрвэл” Маркийн үзэсгэлэн



# Марк, үнэт цаас




**1142**
Д.Данзанравжаа
2023.12.28








**1116**
Туулай жил
2023.01.13







**1117**Монгол Улс, Их Британи,
Умард Ирландын нэгдсэн хаант
улсын хооронд дипломат харилцаа
тогтоосны 60 жил
2023.01.23







1118
Монголчуудын мөсний наадам
2023.02.12







1119
Үнэт эрдэнийн чулуу
2023.03.01






1121
Монгол-Японы
соёлын харилцаа
2023.05.29
















1122
Ху хамтлаг
2023.05.31

1120
Одон зурхай
2023.03.10




1123
Монгол Улсын Ардын уран
зохиолч Шагдарын Дулмаа
2023.06.02






1124
Хэнтий аймаг - 100 жил
2023.06.23







1125
Архангай аймаг - 100 жил
2023.07.01







1126
Завхан аймаг - 100 жил
2023.07.03







1127
Төв аймаг - 100 жил
2023.07.05















1128
Монголч эрдэмтэд
2023.08.11

1129, 1130
Пап Францисын Монгол улс
дахь айлчлал
2023.08.31













1131
Нийслэлийн ерөнхий боловсролын 1 дүгээр
сургуулийн 100 жил
2023.09.20













1132, 1133
Сансар судлал
2023.10.04







1134
Зууны манлай Дуурийн дуучин Цэвэгжавын Пүрэвдорж
2023.10.14







1135
Монгол улс НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн
байгууллагад элсcэний 50 жил
2023.10.16







1136
Монгол улс, Канад улсын хооронд
дипломат харилцаа тогтоосны 50 жил
2023.11.15













1137, 1138
Адуун сүрэг
2023.12.05







1139
Мөстлөгийн үеийн амьтад
2023.12.21




1140
Хөшөө чулууны бичиг
2023.12.21



















1141
Монгол шаазан
2023.12.24

1142
Д.Данзанравжаа
2023.12.28







МОНГОЛЧУУДЫН МӨСНИЙ НААДАМ - ICE FESTIVAL OF THE MONGOLS
MONGOLIA 3000₮
MONGOLIA 3000₮







# Санхүүгийн ажлын хүрээнд

## ШУУДАНГИЙН НИЙТ СОЛИЛЦООНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2019-2023 он | ширхэг




## ОРЛОГО, ЦЭВЭР АШИГ | 2019-2023 он, сая.төгрөг

| Дансны нэр | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|---|
| **НИЙТ ОРЛОГО** | **16,725.0** | **18,231.9** | **20,932.8** | **20,391.5** | **25,397.8** |
| **Татварын дараах цэвэр ашиг** | 1,103.6 | 557.9 | 400.0 | 451.3 | 1,967.7 |




## НИЙТ ХӨРӨНГӨ | 2018-2022 он сая.төгрөг

| Тайлангийн үзүүлэлт | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он | Төгрөг | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **33,484.5** | **37,366.3** | **32,095.0** | **43,511.4** | **38,377.0** | **(5,134.4)** | **-11.8%** |
| **Эргэлтийн хөрөнгө** | 24,463.4 | 27,606.0 | 22,346.3 | 32,998.0 | 27,571.9 | (5,426.1) | -16.4% |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | 9,021.1 | 9,760.2 | 9,748.7 | 10,513.4 | 10,805.1 | 291.7 | 2.8% |

| | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|---|
| **Эргэлтийн хөрөнгө** | 73.1% | 73.9% | 69.6% | 75.8% | 71.8% |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | 26.9% | 26.1% | 30.4% | 24.2% | 28.2% |

## Санхүүгийн ажлын хүрээнд



## НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ | 2019-2023 он сая.төгрөг

| Тайлангийн үзүүлэлт | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он | Төгрөг | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт өр төлбөр ба эздийн өмч** | **33,484.5** | **37,366.3** | **32,095.0** | **43,511.4** | **38,377.1** | **(5,134.3)** | **-11.8%** |
| **Өр төлбөр** | 10,560.9 | 13,389.8 | 7,309.4 | 18,519.8 | 12,229.7 | (6,290.1) | -34.0% |
| **Эздийн өмч** | 22,923.6 | 23,976.5 | 24,785.6 | 24,991.6 | 26,147.4 | 1,155.8 | 4.6% |

| | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|---|
| **Өр төлбөр** | 31.5% | 35.8% | 22.8% | 42.6% | 31.9% |
| **Эздийн өмч** | 68.5% | 64.2% | 77.2% | 57.4% | 68.1% |



## Санхүүгийн ажлын хүрээнд



## МӨНГӨН ХӨРӨНГӨ БА БУСАД ХӨРӨНГӨ | 2019-2023 он сая.төгрөг

| | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он | Төгрөг | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Нийт хөрөнгө** | **33,484.5** | **37,366.3** | **32,095.0** | **43,511.4** | **38,377.1** | **(5,134.3)** | **-11.8%** |
| **Мөнгөн хөрөнгө** | 16,648.9 | 21,059.0 | 14,304.0 | 19,386.0 | 16,148.6 | (3,237.4) | -16.7% |
| **Бусад хөрөнгө** | 16,835.6 | 16,307.3 | 17,791.0 | 24,125.4 | 22,228.5 | (1,896.9) | -7.9% |

| | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|---|
| **Мөнгөн хөрөнгө** | 49.7% | 56.4% | 44.6% | 44.6% | 42.1% |
| **Бусад хөрөнгө** | 50.3% | 43.6% | 55.4% | 55.4% | 57.9% |

## САНХҮҮГИЙН ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТ |2021-2023 он

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|
| **Цэвэр ашиг** | төгрөг | 400,046,154.68 | 451,283,091.44 | 1,967,715,030.31 |
| **Нийт хувьцааны тоо** | ширхэг | 99,586,363 | 99,586,363 | 99,586,363 |
| **Нэгж хувьцааны үнэ** | төгрөг | 1,350.00 | 994.84 | 847.96 |
| **Нэгж хувьцааны дансны үнэ** | төгрөг | 248.9 | 251.0 | 262.6 |
| **Зах зээлийн үнэлгээ** | тэрбум төгрөг | 134.4 | 99.1 | 67.5 |
| **Нэгж хувьцааны өгөөж /EPS/** | төгрөг | 4.02 | 4.53 | 20 |
| **Нийт хөрөнгийн өгөөж /ROA/** | - | 0.0125 | 0.0104 | 0.4995 |
| **Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж / ROA/** | - | 0.0161 | 0.0181 | |
| **Нийт хөрөнгийн эргэц /ROTA/** | - | 0.0147 | 0.0140 | |

## ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ АРИЛЖАА | 2023 он

### Хувьцааны үнийн өөрчлөлт




## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ | 2021-2022 он

| | 2022 он | 2023 он |
|---|---|---|
| **Төрийн өмч** | 66% | 66% |
| **Ард Санхүүгийн Нэгдэл** | 23.6% | 26% |
| **Бусад** | 10.4% | 8% |




МОНГОЛ
ШУУДАН
"МОНГОЛ ШУУДАН"
ХК

# Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18-р зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.*

## АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

(төгрөгөөр)

**Тайлант хугацаа:** 2023-01-01 - 2023-12-31

| Үзүүлэлт | | Өмнөх оны гүйцэтгэл | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 19,385,981,879.08 | 16,148,550,148.05 |
| 1.1.2 | Дансны авлага | 5,886,568,927.89 | 2,667,175,998.77 |
| 1.1.3 | Татвар, НДШ — ийн авлага | 41,101,472.25 | 135,689,028.00 |
| 1.1.4 | Бусад авлага | 332,984,445.92 | 143,565,228.09 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 157,769,001.00 | 0 |
| 1.1.6 | Бараа материал | 3,479,935,861.85 | 3,498,586,855.77 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 3,713,694,026.89 | 4,978,395,671.53 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 0 | 0 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 0 | 0 |
| **1.1.10** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **32,998,035,614.88** | **27,571,962,930.21** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | **0** | **0** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 8,471,058,812.23 | 8,495,852,792.93 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 2,041,818,302.59 | 2,308,742,471.37 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 0 | 0 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 500,000.00 | 500,000.00 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 0 | 0 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 0 | 0 |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 0.00 | 0.00 |

| Үзүүлэлт | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **10,513,377,114.82** | **10,805,095,264.30** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,511,412,729.70** | **38,377,058,194.51** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ** | 0 | 0 |
| **2.1** | **Өр төлбөр** | 0 | 0 |
| **2.1.1** | **Богино хугацаат өр төлбөр** | 0 | 0 |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 17,778,450,709.99 | 10,459,357,649.33 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 0 | 230,582,579.90 |
| 2.1.1.3 | Татварын өр | 168,138,133.12 | 134,928,454.27 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 0 | 14,161,569.68 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 0 | 0 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 0 | 0 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 0 | 0 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 339,069,766.99 | 917,222,935.68 |
| 2.1.1.9 | Нөөц /өр төлбөр/ | 0 | 0 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 234,143,968.36 | 473,428,527.19 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **18,519,802,578.46** | **12,229,681,716.05** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | **0** | **0** |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 0 | 0 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 0 | 0 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 0 | 0 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 0 | 0 |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **0** | **0** |
| **2.2** | **Нийт өр төлбөрийн дүн** | **18,519,802,578.46** | **12,229,681,716.05** |
| **2.3** | **Эздийн өмч** | **0** | **0** |
| 2.3.1 | Өмч: - төрийн | 6,572,700,000.00 | 6,572,700,000.00 |
| 2.3.2 | - хувийн | 3,385,936,300.00 | 3,385,936,300.00 |
| 2.3.3 | - хувьцаат | 0 | 0 |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | 0 | 0 |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 2,538,512,210.45 | 2,538,512,210.45 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,379,919,523.85 | 3,379,919,523.85 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 0 | 0 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 4,300,458,597.23 | 3,714,085,782.53 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | 4,814,083,519.71 | 6,556,222,661.62 |
| **2.3.10** | **Эздийн өмчийн дүн** | **24,991,610,151.24** | **26,147,376,478.45** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **43,511,412,729.70** | **38,377,058,194.50** |

## Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

### АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(төгрөгөөр)

**Тайлант хугацаа:** 2023-01-01 - 2023-12-31

| | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **125,884,989,790.76** | **103,925,063,975.29** |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 14,832,382,704.84 | 15,540,296,005.08 |
| 1.1.2 | Эрхийн шимтгэл, хүлээн авсан мөнгө | 0 | 0 |
| 1.1.3 | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 13,686,589.77 | 0 |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 415,286.40 | 0 |
| 1.1.5 | Татаас, санхүүжилтийн орлого | 3,577,925,614.00 | 0 |
| 1.1.6 | ҮЙА-ны бусад мөнгөн орлого | 78,422,922,605.37 | 111,052,607,085.92 |
| 1.2 | **Мөнгөн зарлагын дүн (–)** | **121,450,100,365.99** | **106,430,984,826.27** |
| 1.2.1 | Ажиллагчдад төлсөн | 7,244,776,405.17 | 8,075,806,596.46 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 2,266,214,006.36 | 2,483,989,133.86 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 2,949,629,551.54 | 2,278,190,902.30 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | 1,819,030,861.01 | 1,882,203,696.27 |
| 1.2.5 | Хүүний төлбөрт төлсөн | 0 | 0 |
| 1.2.6 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 3,240,415,086.86 | 3,605,436,850.60 |
| 1.2.7 | Татварын байгууллагад төлсөн | 1,334,722,721.46 | 122,993,711.52 |
| 1.2.8 | Даатгалын төлбөрт төлсөн | 102,478,616,976.39 | 116,694,757.20 |
| 1.2.9 | ҮЙА-ны бусад мөнгөн зарлага | 87,985,552,376.80 | 86,471,337,634.26 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **4,434,889,424.77** | **–2,505,920,850.98** |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **0** | **0** |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **357,082,910.22** | **650,725,627.87** |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0 | 0 |
| 2.1.2 | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | 0 | 0 |
| 2.1.3 | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 0 | 0 |
| 2.1.4 | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 0 | 0 |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0 | 0 |

| Үзүүлэлт | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 2.1.6 | Хүлээн авсан хүүний орлого | 357,082,910.22 | 650,725,627.87 |
| 2.1.7 | Хүлээн авсан ногдол ашиг | 0 | 0 |
| 2.1.8 | ХО бусад мөнгөн орлого | 0 | 0 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **1,777,149,476.43** | **2,168,349,927.20** |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 1,343,924,826.43 | 2,079,908,727.20 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 283,224,650.00 | 88,441,200.00 |
| 2.2.3 | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 150,000,000.00 | 0 |
| 2.2.4 | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0 | 0 |
| 2.2.5 | Буцаан олгосон зээл болон урьдчилгаа | 0 | 0 |
| 2.2.6 | ХО бусад мөнгөн зарлага | 0 | 0 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-1,420,066,566.21** | **-1,517,624,299.33** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | **0** | **0** |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **0** | **0** |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0 | 0 |
| 3.1.2 | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0 | 0 |
| 3.1.3 | Төрөл бүрийн хандив | 0 | 0 |
| 3.1.4 | СҮА-ны бусад мөнгөн орлого | 0 | 0 |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **192,939,819.90** | **221,219,675.23** |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 0 | 0 |
| 3.2.2 | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0 | 0 |
| 3.2.3 | Хувьцаа буцаан худалдан авахад төлсөн | 0 | 0 |
| 3.2.4 | Төлсөн ногдол ашиг | 192,939,819.90 | 221,219,675.23 |
| 3.2.5 | СҮА-ны бусад мөнгөн зарлага | 0 | 0 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **-192,939,819.90** | **-221,219,675.23** |
| **4** | **Валютын ханшийн зөрүү** | **2,243,086,566.08** | **1,007,333,094.51** |
| 4.1 | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | 5,064,969,604.74 | -3,237,431,731.03 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **14,304,012,274.34** | **19,385,981,879.08** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **19,385,981,879.08** | **16,148,550,148.05** |

## АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**Тайлант хугацаа:** 2023-01-01 - 2023-12-31

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмч | Халаасны хувьцаа | Нэмж төлөгдсөн капитал | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | **Нийт дүн** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2021 оны __-р сарын __-ээрх үлдэгдэл** | 6,572,700,000.00 | 0 | 0 | 3,379,919,523.85 | 0 | 4,300,458,597.23 | 4,602,511,381.17 | **18,855,589,502.25** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | **0** |
| Залруулсан үлдэгдэл | 6,572,700,000.00 | 0 | 0 | 3,379,919,523.85 | 0 | 4,300,458,597.23 | 4,602,511,381.17 | **18,855,589,502.25** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 451,283,091.44 | **451,283,091.44** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | **0** |
| Өмчид гаргасан өөрчлөлт | 3,385,936,300.00 | 0 | 2,538,512,210.45 | 0 | 0 | 0 | -239,710,952.90 | **5,684,737,557.55** |
| Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | **0** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | **0** |
| **2022 оны 12-р сарын __-ээрх үлдэгдэл** | 9,958,636,300.00 | 0 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 0 | 4,300,458,597.23 | 4,814,083,519.71 | **24,991,610,151.24** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | **0** |
| Залруулсан үлдэгдэл | 9,958,636,300.00 | 0 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 0 | 4,300,458,597.23 | 4,814,083,519.71 | **24,991,610,151.24** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 1,967,715,030.31 | **1,967,715,030.31** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | **0** |
| Өмчид гарсан өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 | 0 | (586,372,814.70) | | **(586,372,814.70)** |
| Зарласан ногдол ашиг | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | (225,575,888.40) | **(225,575,888.40)** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | **0** |
| **2023 оны 12-р сарын __-ээрх үлдэгдэл** | 9,958,636,300.00 | 0 | 2,538,512,210.45 | 3,379,919,523.85 | 0 | 3,714,085,782.53 | 6,556,222,661.62 | **26,147,376,478.45** |

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2023

Дизайныг Номун Ерөөл ХХК–д

TheMongolPost

Монгол шуудан /Mongol shuudan/

www.mongolpost.mn

**“МОНГОЛ ШУУДАН” ХК**

Сүхбаатарын талбай–9, ЧД, I хороо, Энхтайвны өргөн чөлөө, Ш/Х–1106,
Улаанбаатар–15160, Монгол улс

+(976) 1800–1613

info@mongolpost.mn